## ДОРНОГОВЬ АЙМАГ, ИХХЭТ СУМ
## “ЦАГААН-ДЭЛ ХАЙЛУУР ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР”



# “ЦАГААН-ДЭЛ” ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**Хянасан:** .............................. **БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын ахлах шинжээч Ц.Жаргалнэмэх**

**Биелэлтийг тайлагнасан:** .............................. **“Хөх Бишрэлт” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Рен Девен/**

.............................. **“Хөх Бишрэлт” ХХК-ийн Үйлдвэрийн дарга /Ц.Ариунцэцэг/**

**2024 он**

# АГУУЛГА


1. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 5
1.1. Төслийн нэр, байршил ..... 5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл ..... 6
1.3. Төслийн талбайн бүтэц зохион байгуулалт ..... 6
1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал ..... 6
1.5. Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж ..... 7
1.6. Баяжуулах үйлдвэрийн технологийн дараалал ..... 8
2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ ..... 10
2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог ..... 10
2.2. Уур амьсгал ..... 10
2.3. Гадаргын ус ..... 10
2.4. Газрын доорх ус ..... 10
2.5. Хөрсөн бүрхэвч ..... 11
2.6. Ургамлан нөмрөг ..... 11
2.7. Амьтны аймаг ..... 11
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ..... 12
3.1. Газрын гадарга, хэвлий ..... 12
3.2. Агаарын чанар ..... 12
3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус ..... 12
3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг ..... 12
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ - 2024 ..... 13
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-2024 ..... 14
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 15
5.1.1. Агаарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ..... 18
5.1.2. Хөрсний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ..... 19
5.1.3. Усны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ..... 21
5.1.4. Ургамалын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ..... 23
5.1.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт ..... 23
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ..... 24
5.2.1. Биологийн нөхөн сэргээлт ..... 25
5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 26
5.3.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулах ..... 27
5.3.2. Дүйцүүлэн нөхөн сэргээлт ..... 27
5.3.3. Биотехникийн арга хэмжээ ..... 28
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 29
5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 30
5.5.1. Биет бус өв ..... 31
5.5.2. Журам ..... 31
5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 33
5.6.1. Үйлдвэрийн болзошгүй осол ..... 35
5.6.2. Химийн бодисын тээвэрлэлт ..... 36
5.6.3. Химийн бодисын хадгалалт ..... 37
5.6.4. Химийн бодисын хаягдал ..... 37
5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 39
5.7.1. Энгийн хог хаягдал ..... 41
5.7.2. Аюултай хог хаягдал ..... 43
5.7.3. Хог хаягдлын тоо бүртгэл хөтлөх ..... 44
5.8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ..... 45
5.8.1. Зөвлөх үйлчилгээний ААН-тэй гэрээлэх ..... 46
5.8.2. Ногоон байгууламж ..... 46
5.8.3. Бичиг баримт ..... 47
5.8.4. Орон нутаг, хамтын ажиллагаа ..... 47
5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ..... 49
5.9.1. Байгаль орчны хяналт шинжилгээ ..... 50
5.9.1.1. Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд ус, хөрс, агаар, ургамал, амьтны дээжлэлт, хэмжилт, шинжилгээ хийх хяналтын цэгүүдийн байршлыг тодорхойлох, тухайн цэгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, кодлол болон дугаарлалтын систем бий болгох ..... 50

5.9.1.2. Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар гүйцэтгэх, үр дүнг боловсруулах ........ 50
5.9.1.3. Хөрсний дээжлэлтийг гүйцэтгэж лабораториудад харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх ........ 51
5.9.1.4. Ундны усны дээж авч химийн болон бактерлогийн үзүүлэлтийг шинжлүүлэх ........ 51
5.10. Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад БОМТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөөний биелэлт ........ 53
5.10.1. Багийн ИНХ-д БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах ........ 54
6. ДҮГНЭЛТ ........ 55

# ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил ........ 6
Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем ........ 7
Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын схем ........ 8
Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн схем ........ 9
Зураг 5. Хурдны хязгаар тогтоосон болон зорчих хэсгийг тогтоосон тэмдгүүд ........ 18
Зураг 6. Цаг уур, орчны шинжилгээний газрын хэмжилтийн үр дүн ........ 18
Зураг 7. Баяжуулах үйлдвэр доторх засвар, үйлчилгээний талбай ........ 19
Зураг 8. Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй дугуйт ачигч ........ 19
Зураг 9. Баяжуулах үйлдвэр доторх засвар, үйлчилгээний талбай ........ 20
Зураг 10. Асгаралттай тэмцэх иж бүрдэл байрлуулсан байдал ........ 20
Зураг 11. Шимт хөрсний овоолгод хэлбэржүүлэлт хийж, тарилтад бэлдэж буй байдал ........ 21
Зураг 12. Ус ашигласны төлбөр төлсөн баримт ........ 22
Зураг 13. Хяналтын цооног өрөмдүүлэн гаргуулах ажлын төлбөр төлсөн баримт ........ 22
Зураг 14. ХАБЭА-н ажилтан галын аюулаас сэргийлэх сургалт орж буй байдал ........ 23
Зураг 15. Мал, амьтны осол эндэглийн үеийн иж бүрдэл ........ 23
Зураг 16. Овоолгын хэлбэржүүлэлт хийж, тарилтад бэлдэж буй байдал ........ 25
Зураг 17. Тарвага сэргээн нутагшуулах ажил гүйцэтгэх гэрээ ........ 27
Зураг 18. Техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэж буй байдал ........ 28
Зураг 19. Биотехникийн арга хэмжээ ........ 28
Зураг 20. Хэвлүүлсэн номын хэсгээс ........ 31
Зураг 21. Батлагдсан Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам ........ 32
Зураг 22. ХАБЭА-н давтан сургалтын үеэр "Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам"-н сургалт хийж буй байдал ........ 32
Зураг 23. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө ........ 35
Зураг 24. Үйлдвэрийн талбайд байх галын хор ........ 36
Зураг 25. Үйлдвэрийн талбайд байх галын хор ........ 38
Зураг 26. Ангилан ялгалтын хог хаягдлын сав ........ 41
Зураг 27. Хог хаягдлын гэрээ ........ 41
Зураг 28. Ангилан ялгалтын хог хаягдлын сав ........ 42
Зураг 29. Сургалт орж буй байдал ........ 42
Зураг 30. Аюултай хог хаягдлын бүртгэл ........ 43
Зураг 31. Аюултай хог хаягдлын бүртгэл ........ 44
Зураг 32. ХАБЭА-н сургалт авсан бүртгэл ........ 46
Зураг 33. Баяжуулах үйлдвэр орчмын ногоон байгууламж ........ 46
Зураг 34. Үйлдвэрийн экологийн паспорт ........ 47
Зураг 35. Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлаас ........ 48
Зураг 36. Агаарын чанарын хэмжилтийн үр дүн ........ 50
Зураг 37. Хөрсний дээжлэлтийн лабораторийн шинжилгээний хариу ........ 51
Зураг 38. Усны дээжний лабораторийн шинжилгээний үр дүнгүүд ........ 52

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. БОМТ-2024 биелэлт бүлэг тус бүрээр ........ 14
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 16
Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ........ 24
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 26
Хүснэгт 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 29

Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт................................ 30
Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ....................................................... 33
Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт .......................................................... 39
Хүснэгт 9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ..................................................... 45
Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт........................................................... 49
Хүснэгт 11. Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад БОМТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөөний биелэлт ........................................................................................................................ 53

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. БОМТ 2024-ийн хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн хуудас
Хавсралт 2. Тарвага сэргээн нутагшуулах ажил гүйцэтгэх гэрээ
Хавсралт 3. Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх ажлын гэрээ
Хавсралт 4. Нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах комисс томилох тухай захирамж
Хавсралт 5. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах акт
Хавсралт 6. Түүхэн болон газар нутгийн танилцуулга ном хэвлүүлэх ажлын төлбөрийн нэхэмжлэх
Хавсралт 7. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
Хавсралт 8. Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээ
Хавсралт 9. Аюултай хог хаядлын дагалдах бичиг
Хавсралт 10. Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээ
Хавсралт 11. Аюултай хог хаядлын дагалдах бичиг
Хавсралт 12. Мод худалдан авсан нэхэмжлэх
Хавсралт 13. Ус ашиглуулах дүгнэлт
Хавсралт 14. Ус ашиглах гэрээ
Хавсралт 15. Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ
Хавсралт 16. Иххэт сумын Баян багийн иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл

# 1. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Жонш баяжуулах үйлдвэр” нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт Монголросцветмет ХХК-ний ашиглаж байсан Хамар-Усны хайлуур жоншны ордын ил уурхайгаас олборлож гаргасан балансын бус жоншны хүдрийн овоолгыг түшиглэн жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан бөгөөд 2021 онд “Сити-Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайшаншин юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэж жилд бүрэн хүчин чадлаараа 300.0 мян.тн хүдэр боловсруулан баяжуулж, ФФ97 маркийн 76.3 мян.тн жоншны баяжмалыг гаргах хүчин чадалтайгаар ажиллахаар ТЭЗҮ /тодотгол/-ыг “Ертөнцийн зүг” ХХК-иар боловсруулуулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал газрын тосны газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 11-р сарын 23-ны өдрийн Т/20-11-03 тоот дүгнэлтээр баталгаажуулжээ.

“Хөх бишрэлт” ХХК нь “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2017 онд “Ашид ананда” ХХК-иар хийлгүүлж, 2018 онд “Ашид ананда” ХХК-иар 2022 онд “EACC” ХХК-иар нэмэлт тодотголыг тус тус хийлгэж, БОАЖЯ-р батлуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618-р тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Хөх Бишрэлт” ХХК нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж, тус журмын дагуу байгуулагдсан ажлын хэсэгт дээрх төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлүүлж 90.1%-ийн үнэлгээ авсан болно */Хавсралт 1. БОМТ-2024-ийн хэрэгжилтийг үнэлж дүгнэсэн хуудас/*.

Үйлдвэрийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол улсын хууль, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, өмнөх жилийн ажлын хэсгийн дүгнэлтээр гарсан зөвлөмж зэргийг удирдлага болгож, төслийн хэмжээнд 2024 онд хийгдэх үйл ажиллагаатай уялдуулан боловсруулж БОАЖЯ-р батлуулсан.

## 1.1. Төслийн нэр, байршил

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Цагаан Дэлийн жонш баяжуулах үйлдвэр” төсөл нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 345 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 50 км, Иххэт сумаас баруун тийш 5 км-т оршиж байна.




*Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил*

## 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл

| | |
|---|---|
| **Аж ахуйн нэгжийн нэр:** | “Хөх Бишрэлт” ХХК |
| **Аж ахуйн нэгж бүртгэлийн дугаар:** | 9019078088 |
| **Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:** | Гадаад худалдаа |
| **Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:** | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо, Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж, 35-3 тоот |
| **Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:** | Гүйцэтгэх захирал Рен Девен, 96620509, huhbishrelt.5878@yahoo.com |
| **Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:** | Үйлдвэрийн дарга Ц.Ариунцэцэг, 99153477, huhbishrelt.5878@yahoo.com |

## 1.3. Төслийн талбайн бүтэц зохион байгуулалт

Жонш баяжуулах үйлдвэрийн дэд бүтэц, зохион байгуулалтийн хувьд түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, нунтаглан баяжуулах хэсэг, баяжмал шүүн хатаах хэсэг, баяжмал савлах, хадгалах хэсэг, хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сав, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, урвалж бодисын агуулах, цахилгаан хангамжийн хэсэг, хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг, ажилчдын байр гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

## 1.4. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал

Цагаан Дэл жонш баяжуулах үйлдвэр нь жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан. 2021 онд төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотгол хийгдэж “Сити Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайншаншин Юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэн жилд 300.0 мян.тонн хүчин чадалтайгаар ФФ97 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 2017 онд бүрэн хэрэгжиж, 2018 оноос эхлэн бүтээгдэхүүн гаргах, үйл ажиллагаа эхэлсэн байдаг.

## 1.5. Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж

Жоншны хүдэр боловсруулалтын технологийн процесс дараах схемийн дагуу явагдана. Үүнд:

- Хүдрийг 5.0 мян.м2 талбайд овоолж дундажлах:
- Том бутлалтын хэсэг
- Дунд бутлалтын хэсэг (хяналтын шигшилттэй)
- Нунтаглалт (ангилалтын битүү циклээр ажиллах)
- Үндсэн флотаци, хяналтын флотаци, 6 үе шаттай цэвэрлэгээний флотаци,
- Баяжмалын өтгөрүүлэлт,шүүх , хатаах
- Хаягдлын аж ахуй зэрэг процессоос бүрдэнэ.




*Зураг 2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем*




*Зураг 3. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын схем*

## 1.6. Баяжуулах үйлдвэрийн технологийн дараалал

***Хүдэр бутлалт:***

Баяжуулах үйлдвэрийн хүдэр бутлах хэсэг нь 2 шатны бутлуур, 1 шатны шигшүүрээс бүрдэнэ. Анхдагч хүдрийг хяналтын шигшилттэй 2 шатны бутлалтын схемээр буталж хүдэрийн ширхэглэлийг 12мм болгоно.

Анхдагч хүдрийн овоолгоос утгуурт ачигчийн тусламжтай хүдрийг хүлээн авах бункерт тэжээх бөгөөд бункерын доор суурилагдсан хавтант тэжээгүүр нь нэгдүгээр шатны хацарт бутлуурыг тэжээнэ. Нэгдүгээр шатны хацарт бутлуурын хүлээн авах хүдрийн хамгийн том ширхэглэл -400 мм байх бөгөөд бутлуураас -80 мм-ийн ширхэглэлтэй хүдэр гарна.

Хяналтын шигшилтийн зорилго нь бутлагдсан хүдрийн ширхэглэлд хяналт тавих болон хоёрдугаар шатны бутлуурт орох шаардлагагүй хүдрийг ялгана. Бутлах цехэд ажиллах шигшүүрийн торны нүхний хэмжээ 15 мм байна. Хяналтын шигшүүрийн торны дээд ангийг (+12 мм-ийн анги) хоёрдугаар шатны бутлуур (1-р шугам хацарт бутлуур, 2-р шугам конусан бутлуур)-т өгөх бөгөөд бутлуураас гарах хүдрийн ширхэглэл -12мм байна.

***Хүдэр жигдрүүлэлт:***

Баяжуулах процесст орж байгаа хүдрийн шинж чанар, хүдэр дэх ашигт болон хорт хольцын агуулгын өөрчлөлт нь үйлдвэрийн хүчин чадал, ажлын горим, баяжмалын чанар, бүтээгдэхүүний гарц, минерал авалт зэрэг нөлөөлдөг. Иймучираас баяжуулах үйлдвэрийн технологийн процессыг хэвийн жигд явуулах зорилгоор хүдэр жигдрүүлэлтийн ажил хийгддэг. Жонш олборлогчдоос нийлүүлж буй түүхий эдийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр жигдрүүлэх талбайд зөөвөрлөн авчирч, жоншны агуулга болон хүдэр дэх карбонатын агуулгаас хамааруулан үечлэн овоолго байгуулах замаар хүдрийг жигдрүүлэн баяжуулахад бэлтгэн хадгална. Хүдрийг холих үедээ хүдрийн бүтцийн чанарыг судлах шаардлагатай.

***Баяжуулалт:***

Баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, нунтаглан баяжуулах хэсэг, баяжмал шүүн хатаах хэсэг, баяжмал савлах,хадгалах хэсэг,хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг,эргэлтийн усны сав, цэвэр усны худаг, ус дамжуулах насос,урвалж бодисын агуулах,цахилгаан хангамжийн хэсэг,хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг,ажилчдын байр контор зэргээс бүрдэнэ.




*Зураг 4. Баяжуулах үйлдвэрийн схем*

# 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

## 2.1. Газрын гадаргын тогтоц ба онцлог

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Цагаан Дэлийн жонш баяжуулах үйлдвэр” нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 345 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 50 км, Иххэт сумаас баруун тийш 5 км-т орших байна. Үйлдвэрийн байрлах нутаг дэвсгэр болох Дорноговь аймгийн Иххэт сум нь Төв Азийн их цөл өндөрлөгийн умард хаяанд байрладаг. Үйлдвэр байрлах сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий заримдаг цөлийн бор саарал, цайвар бор, хужир мараат хөрстэй, хялгана, харганат цөлийн хээр алаг өвст ургамалтай, байгалийн хээржүү цөл хамаарна. Төсөл байрлах талбай нь Дорноговь аймгийн Иххэт сум нь далайн түвшнээс 937-1380 м өргөгдсөн байна.

## 2.2. Уур амьсгал

“Хөх Бишрэлт” ХХК-ийн Жонш баяжуулах үйлдвэр байрлах Дорноговь аймаг нь уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар мужид багтана. Манай орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их агуурииг 33.6 градус, өвөлдөө хүйтэх боловч зундаа аагим халуун болно.

Жилийн явцад агаарын темпаратурын хамгийн их утга нь 7 дугаар сард, бага утга нь өвөл 1 дугаар сард тус тус ажиглагддаг байна. Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын темпаратур +22.1°C хамгийн хүйтэн 1 дугаар сарын дундаж агаарын темпаратур -19.1°C байна. Агаарын үнэмлэхүй хамгийн их темпаратур +33.5°C хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага темпаратур -31.1°C хүрч хүйтэрсэн байна.

## 2.3. Гадаргын ус

Үйлдвэр байрлах нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт хамаарна. Үйлдвэрийн талбай орчим гадаргын усны сүлжээ муу хөгжсөн, байнгын урсацтай гол горхи болон нуур байхгүй. Умард говийн усны сав газрын хүрээнд гадаргын усны нөөц хомс тул сав газар дахь жижиг нуур, тойром, гол горхиудад ус судлалын байнгын харуул бүхий ажиглалт, хэмжилтийн сүлжээ байхгүй. Сав газрын гадаргын усны сүлжээний нягтшил буюу 1 км2 талбайд ногдох голын урт нь маш бага (0.01км/км2) бөгөөд сав газрын хэмжээнд хамгийн их урсац бүрдэлт нь сав газрын хойд, баруун хойд хэсэгт ажиглагдана.

## 2.4. Газрын доорх ус

“Хөх бишрэлт” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Жонш баяжуулах үйлдвэр” байрлах нутаг дэвсгэр нь Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарах ба энэхүү сав газрын гидрогеологийн нөхцлийн гол онцлог нь төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах, ихэнх нөхцөлд хоорондоо нарийн хүзүүвчүүдээр холбогдсон, олон төрлийн ус агуулагч үе, давхарга, бүрдэл, ан цавын усжсан бүс бүхий газрын доорх усны сав газар юм. Газрын доорх усны тэжээгдлийн бүс нь янз бүрийн насны өгөршил, тектоникийн хагарал, эвдрэл, ан цавшилт эрчимтэй өртсөн түрмэл (интрузив), бялхмал, тунамал, хувирмал үндсэн чулуулгаас зонхилж тогтсон байна.

Газрын доорх усны хуримтлал болон хөлийн бүс нь дөрөвдэгч, голоцены настай аллюви, пролюви, нуур, салхины гаралтай сэвсгэр хурдасны зузаалаг, дахь уст үе, давхарга, неоген, палеоген, цэрдийн настай тунамал хурдасны зузаалаг дахь нүх сав-давхраасын уст давхарга, бүрдэл, юра, триас, пермийн настай эх газрын гарал үүсэлтэй чулуулгийн зузаалаг дахь ан цавын усжсан бүсээс бүрдсэн хөндий, хотгор, хоолой зэрэг нам доор газрууд хамрагдана.

Газрын доорх усны хөдөлгөөний ерөнхий зүй тогтол нь өндөрлөг хэсгээсээ нам дор газар луугаа чиглэх ба бага зузаантай дөрөвдэгчийн настай сэвсгэр хурдас нь өөрийнхөө доор байрлах бусад ус агуулагч давхарга руу газрын доорх усыг нэвтрүүлэх үүргийг гүйцэтгэдэг. Сав газрын өндөрлөг хэсгүүдээр тархсан үндсэн чулуулгийн массивын гадаргуу орчимд ихэвчлэн экзогений гарал үүсэлтэй харьцангуй жигд бус, эмх замбараагүй тархалттай ан цавшилын бүс үүссэн байдаг. Эдгээр ан цавын бүсэд газрын доорх ус

тодорхой хэмжээгээр хуримтлагдах боломжтой боловч биеэ даасан уст давхарга ховор ихэвчлэн тэжээлийн гадаад мужийн үүргийг гүйцэтгэнэ.

## 2.5. Хөрсөн бүрхэвч

Үйлдвэрийн талбайд хамаарах газар нь 1230-1260 метрийн үнэмлэхүй өндөртэй нам уулс болон гүвээрхэг тэгшивтэр талархаг газарт байрлана. Үйлдвэрийн талбайд тархсан хөрсөн бүрхэвч нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтаар хархүрэн, хүрэн хөрс зонхилон тархсан Бор өндөр уул баяны тойрогт хамрагддаг. Энд өргөрөгийн бүсийн зүй тогтолтой уялдан хүрэн хөрс бөгөөд эзэмшил талбайн зүүн хэсэг дэх сайрын гольдролд ул хөрсний усны түвшин, эрдэсжилтээс хамаарч сайрын сул хөгжилтэй хөрс багахан газарт тархдаг.

## 2.6. Ургамлан нөмрөг

Үйлдвэрийн талбай нь ургамал-газарзүйн тойргоор Дундаж Халхын хээрийн тойрогт байрлах боловч Дорно–Говийн цөлөрхөг хээрийн тойрогт шилжих хил залгаа бүс нутагт байрлаж байна. Энд хойноосоо Дундад халхын хээрийн үет ургамлын төлөөлөл өмнөөсөө цөлөрхөг хээрийн жижиг сөөг сөөгөнцөр ургамлын төлөөлөл тохиолдох онцлогтой. Үйлдвэрийн талбай нь Монголын төв хэсгийн боржин бүхий бэсрэг уулс, ухаа гүвээрхэг толгод хоорондын нарийн хотос хоолойд байрлаж байна.

Ерөнхийдөө талбай орчим нь толгодорхог хэсгээр харгана-үетэн ургамлан бүлгэмдэл харин нам хотос, хажуу хэсгээр харгана-үетэн–алаг өвст, гэсэн 2 үндсэн ургамлан бүлгэмдэл тохиолдож байна. Уг ургамлан бүлгэмдлүүдийг дагаж, Гялгар дэрс (*Achnatherum splendens*), Хазааргана (*Cliestogenes squarrosa*), Ширэг улалж (*Carex duriuscula*), Крылов хялгана (*Stipa Krilovi* ), Агь (*Artemisia frigida Willd*), Имт гичгэнэ (*Potentilla bifurca*), Ишгүй гичгэнэ (*Potentilla acaulis*), Жижиг навчит харгана (*Garagana micropylla*), Нарийн навчит харгана (*Caragana stenophylla*), Манан хамхаг (*Bassia dasyphylla*), Аммоны сэдэргэнэ (*Convolus ammoni*), Бага хургалж (*Eragrostis minor*) Шүлхий Шарилж (*Artemisia pectinata*), зэрэг ургамлууд зонхилогч болон дэд зонхилогчоор ургана.

## 2.7. Амьтны аймаг

Үйлдвэр байрлах нутаг дэвсгэрийн орчинд хуурай хээр болон хуурайдуу хээрийн экосистем тархсан.

Амьтны аймгийн хувьд цагаан зээр, үлийн цагаан оготно, монгол чичүүл, монгол тарвага, хярс, мануул, идлэг шонхор, хээрийн бүргэд, шилийн сар, монгол болжмор зэрэг хөхтөн болон шувууд төлөөлөх зүйлд тооцогдоно.

**Хөхтөн амьтан:** Үйлдвэрийн талбай орчим Монгол улсын улаан данс (2006)-ны ховордлын зэргийн үнэлгээгээр “устаж болзошгүй” зүйлийн ангилалд бүртгэгдсэн 1 зүйл, “эмзэг” 1 зүйл, “ховордож болзошгүй” 5 зүйл хөхтөн амьтан тус тус оршин амьдарч байна. Нөгөө талаас “мэдээлэл дутмаг” ангилалд бүртгэгдсэн 5 зүйл хөхтөн амьтад байна.

**Мөлхөгчид:** Мөлхөгчдөөс энэ бүс нутагт 3 овог, 3 төрөлд хамаарах 3 зүйл тархдаг ажээ. Энд тархсан гүрвэл болон могойн зүйлүүд нь Монгол орны хэмжээнд түгээмэл тархацтай юм. Мөлхөгч амьтдын хувьд газрын тос олборлолт, хайгуулын үед хөнөөгдөх эрсдэл харьцангуй бага бөгөөд энэ талбайд тоо толгойн хувьд элбэг, тархацын хувьд түгээмэл амьтад тархсан байна.

**Шувуу:** Үйлдвэрийн талбай орчим 123 зүйлийн шувуу тохиох боломжтой ба тус бүс нутагт хээрийн шувууд зонхилон тархасан байдаг. Шувууны аймгийн хувьд зусаж өндөглөдөг ба хэсэгчлэн нүүдэг шувууд зонхилох (103 зүйл) бөгөөд жилийн турш суурин амьдардаг 19 зүйл, зөвхөн өвөл ирээд буцдаг цөөн шувуу (1 зүйл) байна.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Үйлдвэрээс байгаль орчны бүрдэл хэсгүүд болох газрын гадарга, хэвлий, гадаргын болон газрын доорх ус, хөрс, ургамал зэрэгт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллүүдийг БОННҮ-ний тодотгол тайланд нарийвчлан тусгаж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байдаг.

## 3.1. Газрын гадарга, хэвлий

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хэвлийд үзүүлэх болзошгүй болон зайлшгүй сөрөг нөлөөллүүдийг товч дурдвал:

- Барилгажилт, дэд бүтэц барьж байгуулах болон баяжуулах үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хэвлийн хэлбэр дүрс өөрчлөгдөх,
- Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас хаягдлын талбай, овоолгын талбай тэлэх, барилга байгууламжууд нэмж байгуулах, шинээр зам гаргах,

## 3.2. Агаарын чанар

Жигдрүүлсэн хүдрийг бункерт тэжээх, 2 шатны бутлуураар бутлах, шигших, хүдэр хадгалах талбайд туузан дамжуулгаар буулгах зэрэг бүхий л шат дамжлагуудаас тоос тоосонцор үүсдэг. Мөн идэвхтэй овоолго, эвдрэлд орсон талбай зэргээс хуурай салхитай үед тоос шороо агаарт дэгдэж салхины дагуу тархах зэрэг нь үйл ажиллагаанаас агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл болж болзошгүй юм.

## 3.3. Хөрсөн бүрхэвч, гадаргын болон гүний ус

Үйл ажиллагаанас гадаргын болон гүний усанд үзүүлэх гол болон болзошгүй нөлөөлөл нь хаягдлын далан болон химийн бодисын агуулхаас бохирдуулагч бодис алдах, шатах тослох материал, хатуу болон шингэн хог хаягдлын талбайгаас бохирдол үүсэх зэрэг юм.

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл нь шинээр шимт хөрсний хуулалт хийгдэх газарт үүсэх хөрсний эвдрэл ба бүтэцийн алдагдал, үйлдвэрийн дотоод замаар зорчих техникийн нөлөөгөөр үүсэх өнгөн хөрсний талхагдал, төслийн талбайгаас үүсэх тоосонцорын тархалт гэсэн өдөр тутамд үүсч байгаа сөрөг нөлөөллөөс гадна авто зогсоол ба засвар үйлчилгээний талбай орчимд үүсэх шатах тослох материалын цэгэн бохирдол, ахуйн гаралтай органик ба хатуу, шингэн хог хаягдлаас үүдэлтэй механик болон нянгийн бохирдол гэсэн болзошгүй сөрөг нөлөөллүүд байна.

## 3.4. Ургамлан нөмрөг, амьтны аймаг

Жонш баяжуулах үйлдвэрийн 2022 онд хийгдсэн БОННҮ-ний тодотгол тайланд төслийн талбай орчим Монгол улсын улаан данс (2006)-ны ховордлын зэргийн үнэлгээгээр “устаж болзошгүй” зүйлийн ангилалд бүртгэгдсэн 1 зүйл, “эмзэг” 1 зүйл, “ховордож болзошгүй” 5 зүйл хөхтөн амьтан тус тус оршин амьдарч байгаа талаар тусгасан байдаг. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дуу чимээнээс амьтад дайжих, зам, дэд бүтэц байгуулснаас үүдэн амьдрах орчин алдагдах зэрэг болно.

Харин ургамлан нөмрөгт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл нь дэд бүтэц, барилга, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас үүдэн ургамлан нөмрөг талхлагдах юм.

# 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ - 2024

“Хөх Бишрэлт” ХХК нь жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа явагдах газар нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг боломжит хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн талуудын оролцоог хангасан хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж мөн нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьж байна.

Бид 2024 онд Үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна,

Үйлдвэрийн 2024 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-ний гол зорилт нь жонш баяжуулалтын үйл ажиллагаа, химийн бодис тээвэрлэх, хадгалах болон ашиглах, хог хаягдлыг түр хадгалах, тээвэрлэх зэрэг үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэх зардал, баримтлах хууль эрх зүйн орчныг тодорхойлох, мөн байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оршино.

Бид 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгож, үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөсөн болно.

Бид үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь тусгай зөвшөөрөлтэй талбай, түүнээс гадна ОХШХ-т багтсан хяналт шинжилгээний цэгүүд хамаарна.

# 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ-2024

“Цагаан Дэл” хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 66 төсөвт болон төсөвт бус арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2024 оны 10-р сарын 31-ний өдрийн байдлаар БОМТ-ний биелэлт **97.7%,** нийт БОрчны арга хэмжээнд **66.0 сая төгрөг** төсөвлөснөөс, гүйцэтгэлээр **252.75 сая** төгрөг зарцуулсан байна. Доорх хүснэгтэд 2024 оны БОМТ-ний хэрэгжилтийг бүлэг тус бүрээр тусгав. БОМТ-ний хэрэгжилттэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллүүдийг уг тайлангийн холбогдох бүлгүүдээс харна уу.

**Хүснэгт 1. БОМТ-2024 биелэлт бүлэг тус бүрээр**

| № | БҮЛЭГ | БИЕЛЭЛТ |
|---|---|---|
| **1** | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 97% |
| **2** | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 100% |
| **3** | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 100% |
| **4** | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 100% |
| **5** | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох | - |
| **6** | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 100% |
| **7** | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 93% |
| **8** | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 90% |
| **9** | Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 100% |
| **10** | БОМТ-2024 хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь | 100% |
| **11** | **2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** | **97.7%** |

## 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам", "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө" боловсруулах зөвлөмжийн дагуу уурхайн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваасан. Тус бүрэлдэхүүн хэсэг болох агаар, хөрс, гадаргын ба газрын доорх ус, амьтан, ургамал, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн энэхүү төлөвлөгөөг боловсруулсан.

БОННҮ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн төслийн 2024 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй 11 сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ бүрд тухайн сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, шаардагдах төсөв, баримтлах стандарт, хуулийн шаардлагыг тусгасан болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 17 арга хэмжээ төлөвлөснөөс 17 ажлыг хэрэгжүүлсэн буюу тогтмол хэрэгжиж Тус төлөвлөгөөний хэрэгжилт 11-р сарын 30-ны өдрийн байдлаар 97%-тай байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажлуудын биелэлтийн тайлбарыг доорх хүснэгтээс, мөн нотлох баримтыг хавсралтаас харна уу.

Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн товч тайлбарыг Хүснэгт 2. -с, дэлгэрэнгүйг бичвэр мэдээллийг тайлангийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 0, бүлгүүдээс харна уу.

**Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| **Агаар** | | | |
| 1 | Нам даралтын халаалтын зуухнаас гарах утаанд агаарт ялгарах бохирдлын хэмжээг тодорхойлуулах, агаарын бохирдуулсны төлбөрийг төлөх | Биелсэн | Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори-д тайлант жилд хүсэлт гарган хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээ хэмжилтүүд хийлгэсэн. |
| 2 | Олон салаа зам гаргахаас сэргийлэх шаардлагагүй замыг хаах, тэмдэг байрлуулах, хурдны хязгаар тогтоох | Биелсэн | Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдэд хурдны хязгаарыг дагаж мөрдөж ажиллаж байна. Мөн хурдны хязгаар тогтоох тэмдэг, тэмдэглэгээ 4 ш шинээр байрлуулсан. |
| 3 | Баяжуулах үйлдвэрийн тоос босох боломжтой байршлуудад тоосны болон агаарын бохирдлын хэмжилтийг тогтмол хийх. Стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Биелсэн | Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори-д тайлант жилд хүсэлт гарган хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээ хэмжилтүүд хийлгэсэн. |
| 4 | Суурин тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийх | Биелсэн | Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээг тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| **Хөрс** | | | |
| 5 | Хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийх | Биелсэн | Үйл ажиллагаанд ашиглагддаг хөнгөн тэрэгнүүдийн засвар үйлчилгээг 5000 км тутамд хийж ажиллаж байна. |
| 6 | ШТС-г байнгын хяналтад байлгаж өдөр тутмын үзлэг хийх | Биелсэн | Холбогдох ажилчид шатахуун түгээх станцад тогтмол үзлэг хийж, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 7 | Тоног төхөөрөмж, хөнгөн тэрэг, технологийн хүнд машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын хөрсөнд нэвчилт үүсгэхгүй талбайд хийх | Биелсэн | Баяжуулах үйлдвэр дотор байрлах бетон талбайд тоног төхөөрөмж, хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хийж ажиллаж байна. |
| 8 | Асгаралттай тэмцэх иж бүрдлийн бүрэн байдлын үзлэгийн сар тутам гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүрд цэнэглэх | Биелсэн | Аюулгүй ажиллагааны ажилтан сар бүр асгаралттай тэмцэх иж бүрдлийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, шаардлагатай тохиолдолд цэнэглэлт хийж ажиллаж байна. |
| 9 | Химийн бодисын агуулахаас асгаралт үүсэхээс сэргийлж тогтмол ажлын байрны үзлэг хийх, аливаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх | Биелсэн | Аюулгүй ажиллагааны ажилтан, баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын агуулахад тогтмол үзлэгийг хийж, аливаа аюул, эрсдэл, асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. |
| 10 | Шимт хөрсний овоолгийн ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах | Биелсэн | Шимт хөрсний овоолгод ургамалжуулалтийн ажлын хүрээнд ургамлын үр тарьсан. |
| **Гадаргын болон газрын доорх ус** | | | |
| 11 | Хаягдлын сангийн тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг хангах, тогтмол үзлэг хийх, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх | Биелсэн | Холбогдох ажилчид хаягдлын сангийн үзлэгийг хуваарийн дагуу хийж ажилласан. |

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| 12 | Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах | Биелсэн | Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон татварын улсын байцаагч нарыг байлцуулан худгуудын тоолуурын заалтын акт үйлдэж, түүн дээр үндэслэн нэхэмжлэх гаргуулан авч, төлбөрийг төлөн ажилласан. |
| 13 | Газрын доорх усны геофизикийн судалгаа хийлгэх, судалгаанаас гарсан үр дүнгээс хамааран хяналтын цооног байгуулах, | Биелсэн | Баяжуулах үйлдвэрийн талбайд газрын доорх усны хяналтын цооног өрөмдүүлэн гаргуулсан. |
| **Ургамал** | | | |
| 14 | Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх | Биелсэн | Тайлант жилд хур тунадас сайн орсон тул зам талбайн усалгааг зөвхөн шаардлагатай тохиолдлуудад хийж ажилласан. |
| 15 | Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх | Биелсэн | Галын аюулаас аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хэрэгжүүлсэн бөгөөд ХАБЭА-н ажилтан нь нийт 76 ажилтанд галын аюулаас сэргийлэх онол болон практик сургалтыг орсон. |
| **Амьтан** | | | |
| 16 | Төслийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх | Биелсэн | Баяжуулах үйлдвэрийн шаардлагатай газруудад мал амьтан орохоос сэргийлсэн хашаа суурилуулах ажлыг хийж байгаа бөгөөд хараахан дуусаагүй байна. Мөн хашаа дагасан мод тарихаар төлөвлөж байна. |
| 17 | Баяжуулах үйлдвэрийн талбай орчимд мал, амьтан эндсэн тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд ашиглах багаж, тоног төхөөрөмжийн иж бүрдэл худалдан авч, бэлэн байдлыг ханган ажиллах | Биелсэн | Мал, амьтны осол эндэгдлийн үед ашиглах тоног төхөөрөмж болон материал бүхий иж бүрдэл бүрдүүлсэн. |

## 5.1.1. Агаарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

### 5.1.1.1. Нам даралтын халаалтын зуухнаас гарах утаанд агаарт ялгарах бохирдлын хэмжээг тодорхойлуулах, агаарын бохирдуулсны төлбөрийг төлөх

Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори-д тайлант жилд хүсэлт гарган хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээ хэмжилтүүд хийлгэсэн. Мөн нам даралтын зуухны их засвар, үйлчилгээний арга хэмжээг хэрэгжүүлсэн.

### 5.1.1.2. Олон салаа зам гаргахаас сэргийлэх шаардлагагүй замыг хаах, тэмдэг байрлуулах, хурдны хязгаар тогтоох

Үйлдвэрийн талбайд тогтсон замуудаар тээврийн хөдөлгөөн үйлддэг бөгөөд автозамуудад хурдны хязгаарын 5, 10 км/цаг явах тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулсан. Төслийн талбайд замын тэмдэг тэмдэглэгээ нийт 4 ш байрлуулсан.




*Зураг 5. Хурдны хязгаар тогтоосон болон зорчих хэсгийг тогтоосон тэмдгүүд*

### 5.1.1.3. Баяжуулах үйлдвэрийн тоос босох боломжтой байршлуудад тоосны болон агаарын бохирдлын хэмжилтийг тогтмол хийх. Стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори-д тайлант жилд хүсэлт гарган хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос, дуу чимээ хэмжилтүүдийг нийт 2 удаа хийлгэсэн. Тухайн хэмжилтүүдийн үр дүнгээр холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй болно.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

MNAS

БАЙГАЛЬ

СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2024/А-273
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Хөх Бишрэлт" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2024.10.05
Сорьцын тодорхойлолт : Хэнтий аймаг Их хэт сум жоншны үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо : 2024.10.07
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м³ | | | ДБА |
| 1 | Бүтлүүр орчим | X/05 | 14:10 | 0.034 | 0.072 | 0.140 | 60 |
| 2 | Үүрэн бууц орчим | X/06 | 15:06 | 0.001 | 0.074 | 0.340 | 64 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт) | | | | 0.450 | 0.200 | 0.500 | 60 |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч : Э.Оюунтуяа
Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний ахлах шинжээч Д.Түмэндэлгэр

*Зураг 6. Цаг уур, орчны шинжилгээний газрын хэмжилтийн үр дүн*

#### 5.1.1.4. Суурин тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийх

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайн засвар үйлчилгээний хүрээнд баяжуулах үйлдвэрийн нам даралтын зууханд их засвар, үйлчилгээг мөн хэрэгжүүлэн ажилласан.



*Зураг 7. Баяжуулах үйлдвэр доторх засвар, үйлчилгээний талбай*

### 5.1.2. Хөрсний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

#### 5.1.2.1.Хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийх

Үйл ажиллагаанд ашиглагддаг хөнгөн тэрэгнүүдийн засвар үйлчилгээг 5000 км тутамд хийж ажиллаж байна. Засвар үйлчилгээний хүрээнд тос, тосолгооны шингэнг солих, шүүрнүүдийг цэвэрлэх болон солих, бусад үзлэг болон үйлчилгээг хийж ажилласан.




*Зураг 8. Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй дугуйт ачигч*

#### 5.1.2.2. ШТС-г байнгын хяналтад байлгаж өдөр тутмын үзлэг хийх

Холбогдох ажилчид шатахуун түгээх станцад тогтмол үзлэг хийж, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант жилд шатахуун түгээх станцад анхаарал татахуйц эвдрэл болон доголдол үүсээгүй болно.

**5.1.2.3. Тоног төхөөрөмж, хөнгөн тэрэг, технологийн хүнд машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын хөрсөнд нэвчилт үүсгэхгүй талбайд хийх**

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагаанд ашиглагддаг хөнгөн тэрэгнүүдийн засвар үйлчилгээг 5000 км тутамд хийж ажиллаж байна. Засвар үйлчилгээний хүрээнд тос, тосолгооны шингэнг солих, шүүрнүүдийг цэвэрлэх болон солих, бусад үзлэг болон үйлчилгээг хийж ажилласан.



*Зураг 9. Баяжуулах үйлдвэр доторх засвар, үйлчилгээний талбай*

**5.1.2.4. Асгаралттай тэмцэх иж бүрдлийн бүрэн байдлын үзлэгийн сар тутам гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүрд цэнэглэх**

Баяжуулах үйлдвэр болон химийн бодисын агуулахад шингээгч материал, аюулын үед ашиглах тоног төхөөрөмж болон модны үртэс бүхий асгаралттай тэмцэх иж бүрдлүүд байрлуулсан. Тухайн асгаралттай тэмцэх иж бүрдлүүдийн үзлэгийг аюулгүй ажиллагааны ажилтан тогтмол хэрэгжүүлсэн бөгөөд шаардлагатай тохиолдолд цэнэглэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.



*Зураг 10. Асгаралттай тэмцэх иж бүрдэл байрлуулсан байдал*

**5.1.2.5. Химийн бодисын агуулахаас асгаралт үүсэхээс сэргийлж тогтмол ажлын байрны үзлэг хийх, аливаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх**

Аюулгүй ажиллагааны ажилтан, баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын агуулахад тогтмол үзлэгийг хийж, аливаа аюул, эрсдэл, асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Тайлант жилд химийн бодисын агуулахын үзлэгээр ямарваа анхаарал татахуйц дутагдал, зөрчил илрээгүй болно.

**5.1.2.6. Шимт хөрсний овоолгийн ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах**

Шимт хөрсний чанар, хэмжээ, хэлбэрийг алдагдахаас сэргийлэн шимт хөрсний овоолгод хэлбэржүүлэлт хийж, зүлэгний үр тарьсан.



*Зураг 11. Шимт хөрсний овоолгод хэлбэржүүлэлт хийж, тарилтад бэлдэж буй байдал*

## 5.1.3. Усны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

**5.1.3.1.Хаягдлын сангийн тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг хангах, тогтмол үзлэг хийх, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх**

Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны ажилтан болон баяжуулах үйлдвэрийн холбогдох ажилчид хаягдлын сан, далан, түүний хамаарал бүхий тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг өдөр тутам хийж ажилласан. Тухайн үзлэгийн үеэр ямарваа нэг анхаарал татахуйц дутагдал, зөрчил, эвдрэл илрээгүй болно.

**5.1.3.2. Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах**

Баяжуулах үйлдвэр болон унд ахуйн хэрэглээнд ашигласан усны хэрэглээ, худгуудын тоолуурын заалтыг Иххэт сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон Татварын улсын байцаагч нарыг байлцуулан актаар баталгаажуулан, төлбөрийн нэхэмжлэхийг гаргуулан ажилласан. Тус төлбөрийн нэхэмжлэх дээр үндэслэн ус ашигласны төлбөрийг холбогдох төрийн дансанд байрлуулан ажилласан байна.

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР №355
2024 оны 05 сарын 31-ны өдөр

| | | |
|---|---|---|
| Төлөгч: Хөх Бишрэлт ХХК<br>Банк: ХААН БАНК | Дт данс<br>5166055499 | ДҮН<br>10,000,000.00 |
| Хүлээн авагч: Дорноговь татварын алба<br>Банк: БАНК | 3240312231078 | |
| Мөнгөний дүн /үсгээр/ Арван сая **төгрөг ..00. мөнгө**<br>Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн<br>Төлбөрийн зориулалт:Барааны болон ажил үйлчилгээний нэр,дагалдах баримтын №<br>Хөх Бишрэлт ХХК рд: 5878756 Үйлдвэрийн зориулалтаар ашигласан усны төлбөр 2024-1 | | |

Дарга................................РЭН.ДЕВЭН
Тамга

Банкинд гүйлгээ хийсэн
2024 ....он...5...сар...31... өдөр
тэмдэг гарын үсэг
ХААН БАНК

*Зураг 12. Ус ашигласны төлбөр төлсөн баримт*

### 5.1.3.3. Газрын доорх усны геофизикийн судалгаа хийлгэх, судалгаанаас гарсан үр дүнгээс хамааран хяналтын цооног байгуулах

Тайлант жилд 2024 оны 5-р сарын 31-ны өдөр “Гранд Холдинг” ХХК-тай Г-05/24 тоот “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. Тус гэрээний дагуу баяжуулах үйлдвэрийн талбайд газрын доорх усны хяналтын цооног өрөмдөх ажлыг хэрэгжүүлсэн. Хяналтын цооног нь 50 м гүнтэй бөгөөд 2025 оны ОХШХ-т тухайн цооногоос хуваарийн дагуу дээжлэлт хийж, Монгол улсад магадлан итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР №329
2024 оны 05 сарын 27-ны өдөр

| | | |
|---|---|---|
| Төлөгч: Хөх Бишрэлт ХХК<br>Банк: ХААН БАНК | Дт данс<br>5166055499 | ДҮН<br>10,000,000.00 |
| Хүлээн авагч: Грандхолдинг<br>Банк: Төрийн банк | 343100032007 | |
| Мөнгөний дүн /үсгээр/Арван сая **төгрөг .. мөнгө**<br>Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн<br>Төлбөрийн зориулалт:Барааны болон ажил үйлчилгээний нэр,дагалдах баримтын №<br>рд: 5021065 сити сүлжээ ХХК -хяналт цооног урьд | | |

Дарга................................РЭН.ДЕВЭН
Тамга

Банкинд гүйлгээ хийсэн
2024 ....он...05...сар...27... өдөр
тэмдэг гарын үсэг
ХААН БАНК

*Зураг 13. Хяналтын цооног өрөмдүүлэн гаргуулах ажлын төлбөр төлсөн баримт*

## 5.1.4. Ургамалын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

### 5.1.4.1.Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх

Тайлант жилд хур тунадас их унасан учир зам талбайн усалгаа тогтмол хийгээгүй. Гэхдээ хур тунадас ороогүй, хуурайшилттай буюу зам талбайгаас тоос босох тохиолдолд усалгааг тухай бүрд хэрэгжүүлэн ажилласан.

### 5.1.4.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх

Галын аюулаас аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хэрэгжүүлсэн бөгөөд ХАБЭА-н ажилтан нь нийт 76 ажилтанд галын аюулаас сэргийлэх онол болон практик сургалтыг орсон.



*Зураг 14. ХАБЭА-н ажилтан галын аюулаас сэргийлэх сургалт орж буй байдал*

## 5.1.5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

### 5.1.4.1. Төслийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх

Баяжуулах үйлдвэрийн шаардлагатай газруудад мал амьтан орохоос сэргийлсэн хашаа суурилуулах ажлыг хийж байгаа бөгөөд хараахан дуусаагүй байна. Тухайн хашаа суурилуулах ажил цаг уур хүйтэрсэнтэй холбоотой түр зогссон бөгөөд 2025 онд дулааны улирал эхэлсний дараа үргэлжлүүлэн хийж, хэрэгжилтийг бүрэн хангахаар төлөвлөж байна. Мөн хашаа дагасан мод тарихаар төлөвлөж байна.

### 5.1.4.2. Баяжуулах үйлдвэрийн талбай орчимд мал, амьтан эндсэн тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд ашиглах багаж, тоног төхөөрөмжийн иж бүрдэл худалдан авч, бэлэн байдлыг хангаж ажиллах

Мал, амьтны осол эндэгдлийн үед ашиглах тоног төхөөрөмж болон материал бүхий иж бүрдэл бүрдүүлсэн.




*Зураг 15. Мал, амьтны осол эндэгдлийн үеийн иж бүрдэл*

## 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

“Хөх Бишрэлт” ХХК нь “Цагаан Дэл” хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг хариуцлагатай байлгах, байгаль орчны нөхөн сэргээлтийг Монгол улсын холбогдох хууль, эрх зүй, стандарт шаардлагуудад нийцүүлэх, тухайн бүс нутгийн цаг уурын онцлог, ордын геологийн тогтоц, орчин нөхцөлд тохирсон байх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлага арга зүйд тулгуурлах, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зэрэг зарчмуудыг баримтлан ажиллаж байна. Тус төлөвлөгөөний товч тайлбарыг Хүснэгт 3. бичвэр мэдээллийг тайлангийн 5.2.1.1-5.2.2.1 бүлгүүдээс харна уу

**Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| **Биологийн нөхөн сэргээлт** | | | |
| **1** | Шимт хөрсний овоолгийн ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах | Биелсэн | Шимт хөрсний чанар, хэмжээ, хэлбэр алдагдахаас сэргийлж 5-р сард зүлэгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлсэн. |
| **2** | Өнгөрсөн жилүүдэд хийгдсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайнуудад шаардлагатай тохиолдолд нэмэрлэн тариалалт хийх | Биелсэн | Өнгөрсөн жилүүдийн нөхөн сэргээлтийн талбайнуудад нэмэрлэн тарилт хийх шаардлага үүсээгүй болно. |

## 5.2.1. Биологийн нөхөн сэргээлт

### 5.2.1.1. Шимт хөрсний овоолгийн ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах

Үйлдвэрийн хаалт болон явцын нөхөн сэргээлт, ногоон байгууламжийн үйл ажиллагаанд хамгийн чухал, шаардлагатай зүйл шимт хөрс байдаг. Шимт хөрсний чанар, хэмжээ, хэлбэр алдагдахаас сэргийлэн овоолгод олон наст болон нэгт наст ургамлын үрийг хольж тарьсан. Тарилт хийхийн өмнө дугуйт ачигч техник ашиглан овоолгын налууг багасгах, ургамал тарих талбайг хэлбэржүүлэн бэлтгэл ажлыг хангасан. Тарьсан ургамлын ургалтыг 2025 онд ажиглалт хийж шалгах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэрлэн тарилтыг хийх болно.




*Зураг 16. Овоолгын хэлбэржүүлэлт хийж, тарилтад бэлдэж буй байдал*

### 5.2.1.2. Өнгөрсөн жилүүдэд хийгдсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайнуудад шаардлагатай тохиолдолд нэмэрлэн тариалалт хийх

Өнгөрсөн жилүүдийн нөхөн сэргээлтийн талбайнуудад нэмэрлэн тарилт хийх шаардлага үүсээгүй болно.

## 5.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

"Хөх Бишрэлт" ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал"-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант жилд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2 ажил төлөвлөсөн. Тус төлөвлөгөөний хүрээнд Иххэт сумын "Хөх Өндөр" нэртэй газарт 1.2 га талбайд хэсэгчилсэн техникийн нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлж холбогдох сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн. Мөн орон нутагтай хамтран ажиллах гэрээний хүрээнд булгийн эх хашиж хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар 100 хувьтай байна.

**Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| **Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулах** | | | |
| 1 | Холбогдох орон нутгийн засаг даргын тамгын газар, БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж болох биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох | Биелсэн | Аймгийн БОАЖГ болон сумын ЗДТГ-ын санал болгосноор тарвага нутагшуулах ажлыг хийлгэхээр 2024 онд судалгааны ажлыг хийлгэсэн. Урьдчилгаа санхүүжилт 21.0 сая төгрөгийн зардалыг шилжүүлсэн. |
| **Дүйцүүлэн нөхөн сэргээлт** | | | |
| 2 | Орон нутгын удирдлагатай зөвшилцөн эзэнгүй орхигдсон эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх | Биелсэн | Орон нутгийн иргэдийн өнгөт чулуу олборлож эвдрэлд орсон газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн. |
| **Биотехникийн арга хэмжээ** | | | |
| 3 | Зэрлэг амьтанд өвс тэжээл өгөх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах | Биелсэн | Тайлант жилийн өвөл 300 боодол өвс 5 аргал хонь амьдардаг байршилд тавьж өгөх арга хэмжээг хэрэгжүүлсэн. |

## 5.3.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулах

### 5.5.1.1. Холбогдох орон нутгийн засаг даргын тамгын газар, БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж болох биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох

Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Иххэт сумын Засаг даргын тамгын газруудтай 2024 онд хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний талаар санал солилцсон. Тухайн байгууллагуудаас Иххэт сумын нутагт Монгол тарвага сэргээн нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр болсон. Сэргээн нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр "Хустайн Цогцолборт Газар" төв ТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Тус гэрээний хүрээнд тайлант жилд тарвага сэргээн нутагшуулах ажлын судалгааг хэрэгжүүлсэн /*Хавсралт 2. Тарвага сэргээн нутагшуулах ажил гүйцэтгэх гэрээ*/.



БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМ "ХӨХ БИШРЭЛТ" ХХК –НЫ УУРХАЙН ДАРГА Ц.АРИУНЦЭЦЭГ

(Тамга)

БАТЛАВ.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:
"ХУСТАЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР" ТӨВ ТББ

ЗАХИРАЛ
Ц.ДАШПҮРЭВ
(Тамга)

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМАНД
МОНГОЛ ТАРВАГА НУТАГШУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 09-р сарын 11–ны өдөр — Улаанбаатар хот

Нэг талаас Дорноговь аймгийн Иххэт сумандбайрлах "Хөх бишрэлт" ХХК /РД:5878759 /, түүнийг төлөөлж Уурхайн дарга Ц.Ариунцэцэг /цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, 40/2-р байр хаягт байрлах "Хустайн цогцолборт газар" төв /РД: 1030914/, түүнийг төлөөлж "Хустайн цогцолборт газар" төвийн захирал Ц.Дашпүрэв /цаашид "Хамтран ажиллагч", хамтад нь "Талууд" гэх/ нар нь Хустайн БЦГ-аас тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 11-р зүйлийн 4-т заасныг үндэслэн Монгол тарвага барих, аймгийн суманд тээвэрлэн хүргэх ажлын хүрээнд энэхүү гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, холбогдох бусад заалт болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү Гэрээний зорилго нь Ажил гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний хавсралт 1-д тодорхойлсон ажил үүргийг /цаашид "ажил, үйлчилгээ" гэх/ Гэрээгээр тохирсон хугацаанд гүйцэтгэх, Захиалагч нь Гэрээгээр тохирсон нөхцөлийн дагуу төлбөр төлөхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хэрэв талууд энэ Гэрээний нөхцөлийн дагуу Гэрээг хугацаанаас өмнө цуцлаагүй эсхүл нэмэлт Гэрээ хийгээгүй бол энэхүү Гэрээ нь 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр эхэлж 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

1.3. Талууд Гэрээгээр харилцан тохиролцож хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ хуулийг дээдэлж, оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, эрх тэгш, шударга, хүндэтгэлтэй, ёс зүйтэй, хууль дээдлэх зарчмыг баримтална.

1.4. Энэхүү Гэрээ нь нэмэлт хавсралтуудтай байх бөгөөд хавсралтууд нь Гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:
- Хавсралт №1: Даалгаврын удирдамж;
- Хавсралт №2: Ажил хүлээн авах акт

ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

2.1. Энэхүү Гэрээний ажлын даалгаварт тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэхэд зарцуулагдах нийт төсөв [redacted] төгрөг ба НӨАТ багтсан болно.

2.2. Төлбөр хийх хуваарь:

1



2.2.1. Төлбөрийн урьдчилгаа 80% болох [redacted] төгрөгийг талууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ.

2.2.2. Төлбөрийн үлдсэн [redacted] төгрөгийг энэхүү Гэрээ, ажлын даалгаварт тусгагдсан ажлын үр дүн, тайланг хүлээлгэн өгсний дараа энэхүү Гэрээний Хавсралт 2-ийн дагуу ажил хүлээн авах багийн дүгнэлтийг үндэслэн ажлын 5 хоногт багтаан шилжүүлнэ.

2.3. Ажил гүйцэтгэгч талын банкны мэдээлэл:
Банкны нэр: ХХБанк
Дансны нэр: "Хустайн цогцолборт газар" төв ТББ
Дансны дугаар: 405002328

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Ажил гүйцэтгэгчийг ажлын даалгавар болон шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

3.2. Захиалагч нь гүйцэтгэсэн ажлын үр дүнг Гэрээнд заасан хугацаанд хүлээн авах үүрэгтэй.

3.3. Захиалагч нь Гэрээгээр тохирсон нөхцөлийг хангасан тохиолдолд Ажил гүйцэтгэгч талд урьдчилгаа төлбөрийг нэрлэсэн дансанд шилжүүлэх үүрэгтэй.

3.4. Захиалагч нь Гэрээгээр тохирсон ажлын гүйцэтгэлийг хавсралт 2-т заагдсан актаар хүлээн авч, Талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан тохиолдолд энэхүү Гэрээгээр тохирсон хугацаанд багтаан Ажил гүйцэтгэгч талын нэрлэсэн дансанд үлдэгдэл төлбөрийг шилжүүлэх үүрэгтэй.

3.5. Захиалагч нь ажлын үр дүнг Хавсралт 2-т заасан актын дагуу хүлээж авснаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

3.6. Ажил гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан эсхүл хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү Гэрээг нэг талын санаачлагчаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо Ажил гүйцэтгэгч талаар нөхөн төлүүлэх эрхтэй.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Ажил гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн Гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

4.2. Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

4.3. Дараах тохиолдолд Захиалагч талд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй:

4.3.1. Ажил гүйцэтгүүлэхээр Захиалагчийн өгсөн зааварчилгаа, даалгавар нь ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр байвал;

4.3.2. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, Ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон тохиолдолд;

4.4. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн өмчлөлд ямар нэгэн доголдолгүй үр дүнг шилжүүлэн өгөх үүрэгтэй.

4.5. Ажил гүйцэтгэгч нь ажлын үр дүн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг хариуцах үүрэгтэй.

4.6. Гэрээнд заасан ажлыг Ажил гүйцэтгэгч биечлэн гүйцэтгэх үүрэгтэй ба Захиалагч талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрийн эрх, үүргийг бусдад шилжүүлэх эрхгүй.

4.7. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн нэрийн өмнөөс шууд болон шууд бусаар Гэрээнд заагаагүй үйл ажиллагаа явуулах эрхгүй.

4.8. Энэхүү Гэрээтэй холбоотой Ажил гүйцэтгэгч эсхүл гуравдагч этгээд өөрийн буруутай үйлдлээс болж бусдад ямар нэгэн байдлаар гэм хор учруулсан тохиолдолд алдагдал болон хохирлыг Ажил гүйцэтгэгч тал бүрэн хариуцаж хохирлыг барагдуулна.

4.9. Ажил гүйцэтгэгч тал Энэхүү Гэрээний хавсралт 1-т заагдсан ажил, үйлчилгээг гүйцэтгэхтэй холбогдон үүсэх бүхий л татварыг хариуцан төлөх үүрэгтэй.

2

*Зураг 17. Тарвага сэргээн нутагшуулах ажил гүйцэтгэх гэрээ*

## 5.3.2. Дүйцүүлэн нөхөн сэргээлт

### 5.5.1.1. Орон нутгын удирдлагатай зөвшилцөн эзэнгүй орхигдсон эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх

Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын тамгын газартай ярилцсаны үндсэн дээр сумын Бүрдэнэ багийн нутагт орших "Хөх Өндөр" нэртэй орон нутгийн иргэдийн өнгөт чулуу зөвшөөрөлгүй олборлож, нөхөн сэргээлт хийлгүй эвдрэлд оруулан орхисон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэх ажлыг "Хөх Бишрэлт" ХХК нь өөрийн техник, ажиллах хүчээр хийхээр гэрээ байгуулан, гүйцэтгэлийг ханган ажилласан /*Хавсралт 3. Дүйцүүлэн нөхөн сэргээлт хийх ажлын гэрээ*/. Нөхөн сэргээлтийн хүрээнд нийт 11.1 га талбайд 2024 оны 10-р сарын 21-ны өдрөөс 10-р сарын 28-ны өдрүүдийн хооронд гүйцэтгэсэн. Гүйцэтгэсэн дүйцүүлэн нөхөн сэргээлтийг Дорноговь аймгийн Иххэт сумын засаг даргын 2024 оны 10-р сарын 21-ний өдрийн А/83 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн /*Хавсралт 4. Нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах комисс томилох тухай захирамж*/.

Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээж авах ажлыг 2024 оны 10-р сарын 29-ны өдөр ажлын хэсэг нөхөн сэргээлтийн талбайд биечлэн танилцаж, актаар баталгаажуулсан байдаг /*Хавсралт 5. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах акт*/.



*Зураг 18. Техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэж буй байдал*

### 5.3.3. Биотехникийн арга хэмжээ

**5.3.3.1. Зэрлэг амьтанд өвс тэжээл өгөх ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах**

Тайлант жилд биотехникийн арга хэмжээний хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран зэрлэг амьтанд өвс, тэжээл тавьж өгөх ажлыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Дорноговь аймгийн нутагт байршин амьдардаг 5 аргал хонинд 300 боодол өвс тавьж өгөх арга хэмжээг хэрэгжүүлсэн.



*Зураг 19. Биотехникийн арга хэмжээ*

## 5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд хамрагдаж байсан нэг өрхөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, тусламж үзүүлэх санал албан ёсоор гаргасан. Гэвч тухайн өрх саналыг хүлээн аваагүй бөгөөд үйлдвэрийн нөлөөллийн бүсээс нүүсэн. Иймд үйлдвэрийн нөлөөллийн бүсэд орших нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай өрх байхгүй болно.

**Хүснэгт 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| **Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ** | | | |
| **1** | 2024 онд Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөт ажил төлөвлөөгүй болно | Хэрэгжиж дууссан | - |

## 5.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Хөх Бишрэлт” ХХК нь түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэн ажиллахыг зорилго болгон ажилладаг. Үүний хүрээнд соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах арга хэмжээнд хувь нэмэр оруулан ажиллахыг зорьж байна.

Компанийн дээрх зорилгын хүрээнд “Хөх Бишрэлт” ХХК нь түүх соёлын өвийн хамгааллын арга хэмжээний хүрээнд 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 3 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь биелүүлэн ажиллалаа. Биелэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгт болон холбогдох дэд бүлгүүдээс харна уу.

**Хүснэгт 6. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| **Биет бус өв** | | | |
| **1** | Иххэт сумын ЗДТГ-тай хамтран биет болон биет бус өврүү чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх | Биелсэн | Иххэт сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан түүхэн ном хэвлүүлэх, байгалийн үзэсгэлэнт болон тусгай хамгаалалттай газар нутгийн танилцуулга ном хэвлүүлэх арга хэмжээнг хэрэгжүүлэн, орон нутгийн иргэдэд тараасан. Сумын нум сумын харвааны холбоонд анхлан суралцгчидад зориулан нум сум авч өгсөн. |
| **Журам** | | | |
| **2** | Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг боловсруулах. | Биелсэн | Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг боловсруулан, батлуулсан. |
| **3** | Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулах сургалт орох. Журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах | Биелсэн | Компанийн ХАБЭА-н давтан сургалттай хамтран Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулан сургалт орсон. |

## 5.5.1. Биет бус өв

### 5.5.1.1. Иххэт сумын ЗДТГ-тай хамтран биет болон биет бус өврүү чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх

Иххэт сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан түүхэн номыг 65.0 сая төгрөгөөр, байгалийн үзэсгэлэнт болон тусгай хамгаалалттай газар нутгийн танилцуулга номыг 25.0 сая төгрөгөөр санхүүжүүлж хэвлэн, орон нутгийн иргэдэд тараасан /*Хавсралт 6. Түүхэн болон газар нутгийн танилцуулга ном хэвлүүлэх ажлын төлбөрийн нэхэмжлэх*/. Мөн Иххэт сумын нум сумын харвааны холбоонд анхлан суралцагчидад зориулан 2.0 сая төгрөгөөр нум сум худалдан авч өгсөн.






**НОМ БҮТЭЭХЭД ОРОЛЦСОН:**

ИХХЭТ СУМ

| | |
|---|---|
| Г.НАМУУНЗУЛ | *(Засаг дарга)* |
| Х.НЭМЭХ | *(ИТХ-ын дарга)* |
| Ц.ЗОЛЗАЯА | *(Засаг даргын орлогч)* |
| А.ДАВААДОРЖ | *(ЗДТГ-ын дарга)* |
| М.ГАНБАТ | *(Байгаль орчны бодлогын мэргэжилтэн)* |
| Д.ЧУЛУУНХОРОЛ | *(Нэгдүгээр багийн Засаг дарга)* |
| Б.СОДМАГНАЙ | *(Хоёрдугаар багийн Засаг дарга)* |
| И.АЛТАН-ОД | *(Гуравдугаар багийн Засаг дарга)* |

МУЗЕЙ, СУРГАЛТ СУДАЛГААНЫ ТӨВ

| | |
|---|---|
| Б.Цэндбаяр | *(Эрдэм шинжилгээний ажилтан)* |
| Н.Сарантуяа | *(Бүртгэл мэдээллийн санч)* |

ИХХЭТ СУМЫН СОЁЛ, СПОРТЫН ТӨВ

| | |
|---|---|
| Н.Мөнхжаргал | *(Соёл, спортын төвийн дарга)* |
| Э.Тунгалаг | *(Музейн арга зүйч)* |
| Ш.Мандалмаа | *(Номын санч)* |
| П.Эрдэнэзул | *(Хөгжмийн багш)* |
| Н.Мөнхнасан | *(Үзвэрийн танхимын үйлчилгээний ажилтан)* |
| Г.Мөнхзул | *(Хөгжмийн техникч)* |
| Н.Нэргүй | *(Үйлчлэгч)* |
| Л.Халзан | *(Зураач)* |
| Д.Түвшинжаргал | *(Нутгийн иргэн)* |
| Ш.Энхбаяр | *(Гэрэл зурагчин)* |
| Х.Эрдэнэбулган | *(Гэрэл зурагчин)* |
| Х.Энхтайван | *(Гэрэл зурагчин)* |

Энэхүү номыг ивээн тэтгэж, хэвлүүлсэн **“ХӨХ БИШРЭЛТ”** ХХК, дэмжиж тусалсан Иххэт сумын нутгийн иргэддээ талархал илэрхийлье.

*Зураг 20. Хэвлүүлсэн номын хэсгээс*

## 5.5.2. Журам

### 5.5.2.1. Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг боловсруулах

Компанийн “Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам”-ыг боловсруулан, Гүйцэтгэх захирлаар батлуулсан.



ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ БОЛОН ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ

1. Зорилго

1.1. Энэхүү Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаарх баримтлах журам (цаашид "Журам гэх")-ын зорилго нь Степ Голд ХХК (цаашид "Компани" гэх)-ийн Алтан Цагаан-Овоо уурхайд хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эхэлснээс хойш үйл ажиллагааны бүх үе шатанд археологи, палеонтологийн олдвор санамсаргүй байдлаар олдсон тохиолдолд уг олдвор, хэрэглэгдэхүүнд ямарваа гэмтэл учруулалгүйгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу хамгаалах, тээвэрлэх, судлуулах, мөн газрын хөрсөн доор байгаа археологи, палеонтологийн дурсгалуудад тохиолдож болзошгүй эрсдэлийг бодитойгоор бууруулахад оршино.

2. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журам нь үндсэн болон гэрээт компанийн нийт ажилтанд хамаарна.

3. Нэр томьёо

3.1. Соёлын өв гэдэг нэр томьёог хүмүүс өөрсдийнх нь тогтмол хувьсан өөрчлөгдөж байгаа үнэт зүйлс, итгэл үнэмшил, мэдлэг, уламжлалын тусгал, илэрхийлэл гэж өмчлөлөөс нь үл хамааран үздэг, өнгөрсөн үеэс өвлөгдөн ирсэн баялаг гэж тодорхойлдог. Монгол Улсын Үндсэн хуулийн 7.1-д "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна." хэмээн заасан бол, Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.1 дэх заалтад "Соёлын өв" гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий өв" хэмээн тодорхойлсон байдаг.

3.2. Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулна:

3.2.1. эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;
3.2.2. эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга;
3.2.3. чулуун зэвсгийн олдворт газар;
3.2.4. хадны зураг, бичээс;
3.2.5. булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;
3.2.6. эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;
3.2.7. хөшөө дурсгал;
3.2.8. эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;
3.2.9. тахилгат газар;
3.2.10. түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;
3.2.11. бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгал.

4. Үүрэг хариуцлага

4.1. **Ерөнхий менежер болон удирдах түвшний ажилтнууд:** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-д, "Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан мэргэжлийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ" хэмээн заасны дагуу Монгол

Хуудас 1 - 4



Улсын Шинжлэх ухааны академийн Түүх, Археологийн хүрээлэнд албан ёсоор шилжүүлэх хүртэлх хугацаанд тус байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу хадгалан хамгаална.

4.2. **Байгаль орчны менежер:** энэхүү журамд заасан шаардлагыг нийт ажилтан мөрдөж ажиллаж байгаа эсэхэд хяналт тавина.

4.3. **Байгаль орчны мэргэжилтэн**: энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжлийн байгууллагад мэдээлэх асуудлыг хариуцна.

4.4. **Байгаль орчны ажилтан:** Төслийн талбайд ажиллаж байгаа үндсэн болон гэрээт компанийн нийт ажилтанд энэ журамд заасан үүрэг хариуцлагыг нь бүрэн ойлгуулах, журмын хэрэгжилтийг хангах үүрэг, ажлын удирдамж өгөх үүрэгтэй. SG-ENV-PROC-008-04 "Байгаль орчны сургалтын журам"-ын дагуу нийт ажилтанд сургалт орох.

4.5. **Нийт ажилтнууд:** энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах үүрэгтэй ба журам зөрчигдсөн тохиолдлыг Байгаль орчны хэлтэст мэдээлнэ. Палеонтологи, археологийн олдвор, хэрэглэгдэхүүн илэрмэгц ажлыг нэн даруй зогсоож, Байгаль орчны хэлтэст мэдэгдэнэ.

5. Горим

5.1. Уул уурхайн төслийн байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний шатанд хийдэг соёлын өвийн суурь судалгаагаар ихэвчлэн тухайн газарт байгаа палеонтологи, археологийн дурсгалыг бүртгэж тогтоодог. Палеонтологийн дурсгал нь газрын хөрсөн дээр ил харагдах хэлбэрээр орших нь тухайн бүс нутагт эрс ховор байдаг. Археологийн дурсгал нь газрын хөрсөн дээр ил харагдах овор хэмжээтэй орших хэдий ч ихэнх дурсгал нь газрын хөрсөн доор далд байдаг тул тэдгээрийг олж илрүүлэх, үнэлэх боломж бага байхаас гадна өртөг өндөр байдаг. Энэхүү журамд үйл ажиллагаа эхэлснээс хойш палеонтологи, археологийн дурсгал болон олдвор олсон буюу байж болзошгүй тохиолдолд уг асуудлыг зохих хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээг тусгав.

5.2.1. **Соёлын өвийн суурь судалгаанд ашигладаг үндсэн аргууд** Төрийн байгууллагууд, мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагуудын судлаач мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх;

5.2.2. Төслийн газрын зургийг соёлын өв бүхий газруудын жагсаалттай тулгаж харьцуулах;
5.2.3. Бүс нутгийн археологийн судалгааны бэлэн материалуудтай танилцах;
5.2.4. Төслийн нөлөөллийн бүсэд хээрийн тандалт судалгааны ажил хийх.
5.2. Барилгын болон малталтын ажлын төлөвлөгөөтэй холбоотойгоор археологи, палеонтологийн дурсгал болон олдвор байж болзошгүй газрыг олж тогтооход "Дурсгалт газрын байршлыг урьдчилан тогтоох аргачлал"-ыг зарим судалгаанд ашигладаг. Эдгээрт голын эрэг дэнж, уулын орой, энгэр, бэл зэрэг тогтцууд хамаарна.

6. Арга хэмжээ

6.1. Энэхүү журмын гүйцэтгэлийн шаардлагын зорилтууд нь:
6.1.1. Төслийн хүрээнд соёлын өвийг хамгаалах асуудалд дэмжлэг үзүүлэх;
6.1.2. Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс соёлын өвийг хамгаалах;
6.1.3. Боломжтой нөхцөлд соёлын өвийн талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, тэдгээрээр бахархах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

6.2. Соёлын өвийн үнэ цэнэ эсвэл ач холбогдлыг илэрхийлсэн талбай, олдвор, эд хэрэглэгдэхүүнийг батлагдсан төслийг хэрэгжүүлэх явцад тооцоолж байгаагүй байрлалд олж болохыг "Степ Голд" (Үнэт металлын компани) ХХК хүлээн зөвшөөрдөг. Тиймээс дараах тохиолдолд төсөлд дээрх гүйцэтгэлийн шаардлагын заалтуудыг мөрдөнө:

6.2.1. Төслийн хүрээнд их хэмжээний малталт, буулгалт хийх, газар хөндөх, үер болох эсвэл байгаль орчинд бусад өөрчлөлт оруулах бол;

Хуудас 2 - 4

*Зураг 21. Батлагдсан Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам*

### 5.5.2.2. Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулах сургалт орох. Журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах

Компанийн ХАБЭА-н давтан сургалтын үеэр тайлант жилд батлагдсан "Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам"-ын талаар танилцуулга сургалтыг орсон.



*Зураг 22. ХАБЭА-н давтан сургалтын үеэр "Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам"-н сургалт хийж буй байдал*

## 5.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бид Жонш байжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэнэ. Байгаль орчин болон баяжуулах үйлдвэрийн хэлтэс нь уурхайд ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт ашиглалт, түүний хаягдал сав баглаа боодлын устгалд хяналт тавьж аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөг боловсруулан ажиллаж түүний дагуу тавигдах шаардлагуудыг биелүүлэн ажиллаж байна.

Бид Байгаль орчин, Аялал Жуулчлалын яамнаас Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Тус төлөвлөгөөний хүрээнд нийт 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тухайн арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж дуусан. Биелэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгт болон 5.6.1-5.6.3-р бүлгээс харна уу.

**Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| | **Үйлдвэрийн болзошгүй осол** | | |
| 1 | Баяжуулах үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөө боловсруулж, холбогдох газраар батлуулах | Биелсэн | Баяжуулах үйлдвэрийн 2024 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн 09 дүрээг аврах ангийн захирагчаар батлуулсан байдаг |
| 2 | Үйлдвэрийн барилга байгууламж бүрд галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах | Биелсэн | Баяжуулах үйлдвэр, ажилчдын оффис, түр амрах байруудын галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас тайлант жилд гаргуулан авсан байдаг. |
| 3 | Үйлдвэрийн талбайд үүсэж болзошгүй аюул, эрсдлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний практик сургалтыг нийт ажилчдад орох | Биелсэн | Үйлдвэрийн талбайд гал түймэр, онцгой байдалд эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын талбайд тогтмол ажлын байрны үзлэгүүд зохион байгуулж, бүх барилга байгууламжийг гал унтраах, утаа мэдрэгч тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулсан. |
| 4 | Аюулгүй ажиллагааны хэлтэс ажлын байр, талбаруудад үзлэг хийж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх | Биелсэн | Аюулгүй ажиллагааны ажилтан болон үйлдвэрийн холбогдох ажилчид тогтмол ажлын байрнуудад үзлэг хийж ажиллаж байна. |
| | **Химийн бодисын тээвэрлэлт** | | |
| 5 | Химийн бодисын агуулахаас бодис үйлдвэр луу тээвэрлэхдээ асгаралтаас урьдчилан сэргийлж ажиллах, зааварчилгаа өгөх | Биелсэн | ХАБЭА-н ажилтан байнгын зааварчилгаа өгдөг. |
| | **Химийн бодисын хадгалалт** | | |
| 6 | Даралтат савласан хийг хүлээж авах шаардлагын дагуу хүлээн авч, ашиглах нөхцөлүүдийн дагуу ашиглах | Биелсэн | Заврын дагуу даралтат савласан хийг хүлээн авсан. |
| 7 | Химийн бодисын тэмдэг тэмдэглэгээр гэмтсэн салсан тохиолдолд яаралтай дахин шинэчлэн наах | Биелсэн | Баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын сав, баглаа боодолд тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд тэмдэг, тэмдэглэгээ муудсан тохиолдол тухай бүрд сольж ажилласан. |
| 8 | Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх, зарцуулалтын тайланг холбогдох байгууллага руу илгээх | Биелсэн | Химийн бодисын зарцуулалт болон ашиглалтад баяжуулах үйлдвэрийн дарга, нярав нар хяналт тавьж ажилладаг. |
| 9 | Химийн бодисын агуулахад засвар, үйлчилгээ хийх, Агуулахын технологийн бүтэц, үзүүлэлт | Биелсэн | Химийн бодисын агуулахад Баяжуулах үйлдвэрийн ажилчид тогтмол үзлэг хийж ажилладаг бөгөөд |

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| | өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дахин дүгнэлт гаргуулан авах | | үзлэгээр аливаа эвдрэл, гэмтэл илэрсэн тохиолдолд тухай бүр засвар хийсэн. |
| | **Химийн бодисын хаягдал** | | |
| **10** | Химийн бодисын сав баглаа боодлыг хадгалах, хоргүйжүүлэх, устгах журмын дагуу аюулгүй хадгалах | Биелсэн | Химийн бодисын сав, баглаа боодлыг цэвэр усаар угааж, саармагжуулан химийн бодисын агуулахад аюулгүй хадгалж ажилласан. |
| **11** | Химийн бодисын сав баглаа боодлын үүсгэсэн хугацаа, тоо хэмжээ, жинг нэг бүрчлэн бүртгэх | Биелсэн | Химийн бодисын агуулах руу сав, баглаа боодол тээвэрлэх тохиолдол бүрд баяжуулах үйлдвэрийн ажилчид бүртгэл хөтөлж, нярав нэгтгэн ажилласан. |
| **12** | Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай ачаа хүлээн авагч буюу аюултай хог хаягдал устгуулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх | Биелсэн | Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах тусгай зөвшөөрөл бүхий “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан. |
| **13** | Үйлдвэр орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох | Биелсэн | Аюулгүй ажиллагааны ажилтан нь баяжуулах үйлдвэрийн галын аюулын үзлэгийг тогтмол хэрэгжүүлсэн. Баяжуулах үйлдвэрийн нийт ажилчдад гал унтраах дадлага сургалтыг тайлант жилд 2 удаа хэрэгжүүлсэн. |

## 5.6.1. Үйлдвэрийн болзошгүй осол

### 5.6.1.1. Баяжуулах үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөө боловсруулж, холбогдох газраар батлуулах

Жонш баяжуулах үйлдвэрийн 2024 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн 09 дүрээг аврах ангийн захирагч, хурандаа Д.Гантулга-аар батлуулсан байдаг /*Хавсралт 7. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө*/.



*ОБЕГ-ын даргын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/75 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт*

БАТЛАВ:
"ХӨХ БИШРЭЛТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ...РЕН ДЕВЕН

ЗӨВШӨӨРСӨН:
ОБЕГ-ЫН ДЭРГЭДЭХ УУЛ УУРХАЙН
09 ДҮГЭЭР АВРАХ АНГИЙН ЗАХИРАГЧ,
ХУРАНДАА Д. ГАНТУЛГА

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН НУТАГТ ОРШИХ ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндсэн АТЗ-ын дугаар: PP-900034

ХЯНАСАН:
УУЛ УУРХАЙН АВРАХ АНГИЙН ТЕХНИК АВРАХ АЖИЛЛАГААНЫ УДИРДАГЧ
АХМАД Д.БАЯРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
"ХӨХ БИШРЭЛТ" ХХК-ИЙН МАРКШЕЙДЕР ИНЖЕНЕР Л.БАТТУЯА

2024 ОН

Scanned with MOBILE SCANNER

*Зураг 23. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө*

### 5.6.1.2. Үйлдвэрийн барилга байгууламж бүрд галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах

Баяжуулах үйлдвэр, ажилчдын оффис, түр амрах байруудын галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас тайлант жилд гаргуулан авсан байдаг.

#### 5.6.1.3. Үйлдвэрийн талбайд үүсэж болзошгүй аюул, эрсдлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний практик сургалтыг нийт ажилчдад орох

Үйлдвэрийн талбайд гал түймэр, онцгой байдалд эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын талбайд тогтмол ажлын байрны үзлэгүүд зохион байгуулж, бүх барилга байгууламжийг гал унтраах, утаа мэдрэгч тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулсан.





*Зураг 24. Үйлдвэрийн талбайд байх галын хор*

Гал түймэртэй тэмцэх болон Гамшгийн тухай хуулийн дагуу Үйлдвэрийн талбайн барилга эрсдэлийн үнэлгээ, бүх хэсэг нэгжүүдэд онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

#### 5.6.1.4. Аюулгүй ажиллагааны хэлтэс ажлын байр, талбаруудад үзлэг хийж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Баяжуулах үйлдвэрийн Аюулгүй ажиллагааны ажилтан болон үйлдвэрийн холбогдох ажилчид аулын байр, талбаруудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлын байрны үзлэгийг тогтмол хийж ажилласан. Төлөвлөгөөт үзлэгийг 7 хоног тутам хийж байгаа бөгөөд төлөвлөгөөт бус ажлын байрны үзлэгийг өдөр тутам хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд аливаа учирч болох аюул, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг тус ажлын байр хариуцсан ажилтантай зөвшилцөн, хэрэгжилтийг ханган ажилласан.

### 5.6.2. Химийн бодисын тээвэрлэлт

#### 5.6.2.1. Химийн бодисын агуулахаас бодис үйлдвэр лүү тээвэрлэхдээ асгаралтаас урьдчилан сэргийлж ажиллах, зааварчилгаа өгөх

"Хөх Бишрэлт" ХХК-ийн Баяжуулах үйлдвэрийн дарга, Аюулгүй ажиллагааны ажилтан нар химийн бодистой харьцан ажилладаг нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, тухайн өдөрт гүйцэтгэх ажлын учирч болох аливаа аюул, осол, эрсдлийн талаар мэдээлэл өгдөг бөгөөд тухайн сөрөг нөлөөллөөс сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээг тодорхойлдог.

## 5.6.3. Химийн бодисын хадгалалт

### 5.6.3.1. Даралтат савласан хийг хүлээж авах шаардлагын дагуу хүлээн авч, ашиглах нөхцөлүүдийн дагуу ашиглах

Даралтат савласан хийг аюулгүй ажиллагааны ажилтан, нярав, үйлдвэрийн дарга нар хүлээн авдаг. Хүлээн авахдаа даралтат савны гаднах хэлбэр, даралт, хавхлага, тэмдэг тэмдэглэгээ зэргийг шалгаж хүлээн авдаг бөгөөд ямарваа нэгэн гэмтэл, эвдрэл илэрсэн тохиолдолд нийлүүлэгч байгууллага руу буцааж ажилласан.

Мөн даралтат савласан хийг баяжуулах үйлдвэрийн талбайд зориулалтын хадгалах саванд байрлуулж, зөвхөн зөвшөөрөгдсөн ажилчид ашиглаж байна.

### 5.6.3.2. Химийн бодисын тэмдэг тэмдэглэгээг гэмтсэн салсан тохиолдолд яаралтай дахин шинэчлэн наах

Баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын сав, баглаа боодолд тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд тэмдэг, тэмдэглэгээ муудсан тохиолдол тухай бүрд сольж ажилласан.

### 5.6.3.3. Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх, зарцуулалтын тайланг холбогдох байгууллага руу илгээх

Химийн бодисын зарцуулалт болон ашиглалтад баяжуулах үйлдвэрийн дарга, нярав нар хяналт тавьж ажилладаг.

### 5.6.3.4. Химийн бодисын агуулахад засвар, үйлчилгээ хийх, Агуулахын технологийн бүтэц, үзүүлэлт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дахин дүгнэлт гаргуулан авах

Химийн бодисын агуулахад Баяжуулах үйлдвэрийн ажилчид тогтмол үзлэг хийж ажилладаг бөгөөд үзлэгээр аливаа эвдрэл, гэмтэл илэрсэн тохиолдолд тухай бүр засвар хийсэн.

## 5.6.4. Химийн бодисын хаягдал

### 5.6.4.1. Химийн бодисын сав баглаа боодлыг хадгалах, хоргүйжүүлэх, устгах журмын дагуу аюулгүй хадгалах

Аливаа химийн бодис ашигласан тухай бүрд сав баглаа боодлыг саармагжуулах, хоргүйжүүлэх үйл ажиллагааг Баяжуулах үйлдвэрийн операторууд Аюулгүй ажиллагааны ажилтан, үйлдвэрийн дарга нарын удирдлага дор хэрэгжүүлэн химийн бодисын агуулахад байрлах аюултай хог хаягдлын агуулахад аюулгүй байдлыг ханган хадгалдаг.

### 5.6.4.2. Химийн бодисын сав баглаа боодлын үүсгэсэн хугацаа, тоо хэмжээ, жинг нэг бүрчлэн бүртгэх

Химийн бодисын агуулах руу сав, баглаа боодол тээвэрлэх тохиолдол бүрд баяжуулах үйлдвэрийн ажилчид бүртгэл хөтөлж, нярав нэгтгэн ажилласан. Аюултай хог хаягдлыг үүсгэсэн хугацаа, төрөл, жин болон хэмжээ тус бүрээр бүртгэн химийн бодисын агуулахад байрлуулан, хадгалж ажилласан.

### 5.6.4.3. Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай ачаа хүлээн авагч буюу аюултай хог хаягдал устгуулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх

Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах тусгай зөвшөөрөл бүхий “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан.

### 5.6.4.4. Үйлдвэр орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох

Аюулгүй ажиллагааны ажилтан нь баяжуулах үйлдвэрийн галын аюулын үзлэгийг тогтмол хэрэгжүүлсэн. Баяжуулах үйлдвэрийн нийт ажилчдад гал унтраах дадлага сургалтыг тайлант жилд 2 удаа хэрэгжүүлсэн.




*Зураг 25. Үйлдвэрийн талбайд байх галын хор*

## 5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Бид үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллахаар зорьж байна.

Бид холбогдох хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүний дагуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэн ажиллахаар 2024 оны төлөвлөгөөнд тусгаж оруулсан.

Тус төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 15 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 14 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 1 арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна. Биелэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгт болон холбогдох дэд бүлгүүдээс харна уу.

**Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| **Энгийн хог хаягдал** | | | |
| 1 | Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ангилан ялгаж, бүртгэх, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | Биелсэн | Хог хаягдлыг ангилж хог хаягдал хадгалах түр цэгт хогийн сав байршуулсан |
| 2 | Ахуйн буюу дахин ашиглах боломжгүй энгийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах, бүртгэл хөтлөх, | Биелсэн | Холбогдох гэрээг байгуулж байнга хамтран ажилладаг.Иххэт сумын ЗДТГ-ын даргатай 2024 оны 01-р сарын 18-ны өдөр №02 тоот гэрээ байргуулсан. |
| 3 | Хог хаягдлын түр цэгт халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийх | Биелсэн | Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулж, аюултай хог хаягдлыг нийлүүлсэн. |
| 4 | Дахин ашиглах боломжтой хаягдлыг /хаягдал мод, төмөр/ өрхийн хэрэгцээнд ашиглах зориулалтаар орон нутгийн малчин иргэдэд олгох | Биелсэн | Сумын хогийн цэг дээрхи ахуйн хог хаягдлыг түрэх, бөөгнүүлэх үйл ажиллагаанд туслах ажлыг сард нэг удаа, хог булшлах булах ажлыг хэрэгжүүлэн ажилласан. |
| 5 | Хог хаягдлын цэгт ангилан ялгалтыг сайжруулах, шаардлагатай газруудад хогийн сав байрлуулах | Биелсэн | Үйлдвэрээс гарч буй хог хаягдлыг төрөлжүүлэн ангилах зориулалтын сав хаягжуулан байрлуулж, нийт ажилчдад хог хаягдлын ангилан ялгалтыг хэвшүүлж ажилласан. Үйлдвэрийн хашаан дортор болон ойролцоох газрын их цэвэрлэгээг сард 1 удаа хийдэг. |
| 6 | Хог хаягдлын ангилан ялгалтад хяналт тавих үзлэг шалгалт хийх | Биелсэн | Түр хадгалах талбайд ангилж байршуулсан. |
| 7 | Компанийн багц дотоод сургалтын хүрээнд нийт ажилчдад хог хаягдалтай холбоотой сургалт зохион байгуулах | Биелсэн | ХАБЭА-н сургалтын дараа нийт ажилчдад сургалт орсон. |

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөв | Биелэлт |
|---|---|---|---|
| **8** | Төслийн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих | Биелсэн | Шаардлагатай тохиолдол бүрд хог хаягдлын тэмдэг тэмдэглэгээг сольж ажилласан. |
| | **Аюултай хог хаягдал** | | |
| **9** | Аюултай хог хаягдал хадгалах сав, талбайг холбогдох шаардлага хангасан байдлаар шинэчлэх, сайжруулах | Биелсэн | Химийн бодисын агуулахад аюултай хог хаягдлыг байрлуулан ажиллаж байна. |
| **10** | Аюултай хог хаягдал тээвэрлэх болон устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгч акт үйлдэх | Биелсэн | Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан. |
| **11** | Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх, устгалд оруулах | Биелсэн | Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан. |
| **12** | Техник тоног төхөөрөмжийн ашигласан хаягдал тосыг үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тосолгоонд дахин ашиглах, тухай бүр ашиглалтын бүртгэл хөтлөх | Биелсэн | Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. |
| **13** | Үйлдвэрт ашиглах химийн бодисын сав баглаа боодлыг цэвэрлэх, ангилан төрөлжүүлж бүртгэх, түр цэгт хадгалах, устгах үйлдвэрт нийлүүлэх | Биелсэн | Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан. |
| **14** | Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авах | Биелээгүй | Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаарыг тайлант жилд гаргуулах аваагүй тул энэхүү ажил хэрэгжээгүй. |
| | **Хог хаягдлын тоо бүртгэл хөтлөх** | | |
| **15** | Үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, БОХ тайланд тусгаж сумын захиргаанд хүргүүлнэ | Биелсэн | Иххэт сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид БОХ тайланг хүргүүлсэн. |

## 5.7.1. Энгийн хог хаягдал

### 5.7.1.1. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ангилан ялгаж, бүртгэх, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Хог хаягдлыг ангилж хог хаягдал хадгалах түр цэгт хогийн сав байршуулсан. Тус хогийн сав нь ангилан ялгалт хийх зориулалт бүхий сав бөгөөд аж ахуйн ажилчид хог хаягдлыг тус ангилан ялгалтыг дагуу хаяж байна.



*Зураг 26. Ангилан ялгалтын хог хаягдлын сав*

### 5.7.1.2. Ахуйн буюу дахин ашиглах боломжгүй энгийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах, бүртгэл хөтлөх

Холбогдох гэрээг байгуулж байнга хамтран ажилладаг. Иххэт сумын ЗДТГ-ын даргатай 2024 оны 01-р сарын 2-ны өдөр №04 тоот гэрээ байгуулсан.



БАТЛАВ:
ИХХЭТ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
Н.ГАНТОГТОХ

БАТЛАВ:
"ХӨХ БИШРЭЛТ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ
РЕН ДЕВЕН

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН ЗДТГ, "ХӨХ БИШРЭЛТ" ХХК-ний БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТЭЙ БАЙГУУЛАХ, "ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ" 2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

№ 02

2023 оны 01 сарын 18-ны өдөр — Иххэт сум

**НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:**

1.1. Гэрээний зорилго нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг дэвсгэрт Ашигт малтмал ашиглагч олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахдаа, тус сумын хөгжилд тодорхой дэвшил үзүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэн, ажлын байрны, орчны бохирдол, хог хаягдлыг хууль журманд нийцүүлэн зайлуулах, хамтран ажиллахад оршино.
1.2. Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд явагдана.
1.3. Нэг талаас Иххэт сумын Засаг даргын Тамгын газрыг төлөөлж Байгаль орчны бодлогын мэргэжилтэн М.Ганбат, нөгөө талаас Хөх бишрэлт ХХК-ний Үйлдвэрийн дарга Ц.Ариунцэцэг нар 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал энэхүү гэрээг байгуулав.

**ХОЁР: ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

2.1. Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын шаардагдах үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэх.
2.2.Иххэт сумын Засаг даргын Тамгын газрын шаардагдах үйлчилгээ, дэмжлэгийг хууль тогтоомжид нийцүүлэн, гэрээнд заасны дагуу үзүүлнэ.
2.3. Уурхайн орчны бохирдолгүй байх, хог хаягдлыг ангилан ялгах замаар түр хадгалах цэгүүд байршуулах, тогтсон хуваарийн дагуу хог хаягдал ачиж зайлуулахад шаардагдах нөхцлийг бүрдүүлэх, хангахыг шаардах эрхтэй.
2.4. Хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд шаардлага тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.

**ГУРАВ: "ХӨХ БИШРЭЛТ" ХХК ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

3.1. Уурхайн орчныг бохирдолгүй байх, түр хадгалах цэгүүд байршуулах, тогтсон хуваарийн дагуу хог хаягдал ачиж зайлуулахад шаардлагатай нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.
3.2. Хог хаягдлын тухай хууль, холбогдох журмын дагуу төлбөр, хураамжийг цаг хугацаанд нь төлөх.
3.3. Хог хаягдлын төлбөрийг, Дорноговь аймгийн Иххэт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 05/08 дугаар тогтоолын хавсралт /Уулын үйлдвэрийн хог хаягдлын үйлчилгээний хураамж/-д заасан төлбөрийн дагуу 1 сард 30'000 /гучин мянга/ төгрөгийг Төрийн банкны 100060500947 тоот дансанд 1 жилээр тооцон 360,000 /гурван зуун жаран мянга/ төгрөгийг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор шилжүүлнэ.
3.4. Сумын орчны бохирдол, хог хаягдал зайлуулах нийтийг хамарсан цэвэрлэгээнд техникийн туслалцаа үзүүлэх, төвлөрсөн хогийн цэгийг улиралд нэг удаа түрэх ажлыг зохион байгуулах.

**ДӨРӨВ: ХАМТРАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

4.1. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачлага гаргаж ажиллана.
4.2. Талууд бичгийн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
4.3. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарах, эсхүл цуцлах тохиолдолд талууд бие биедээ бичгээр мэдэгдэнэ.

**ТАВ: ГЭРЭЭГ ДҮГНЭХ**

5.1. Энэхүү гэрээний биелэлтийг, гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас өмнө буюу ажлын 10 хоногт багтаан 2 тал хамтран дүгнэнэ.
5.2. Гэрээний биелэлтийг хангалттай, хангалтгүй гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ.
5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлснээс үүдэн нөгөө талд ямар нэгэн хохирол учирсан бол буруутай тал нь нөгөө талын хохирлыг барагдуулах үүрэгтэй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ИХХЭТ СУМЫН ЗДТГ-ЫН БО-НЫ БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
М.ГАНБАТ
Утас: 95545559

"ХӨХ БИШРЭЛТ" ХХК ҮЙЛДВЭРИЙН ДАРГА
Ц.АРИУНЦЭЦЭГ
Утас: 99153477

